



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 730

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө ашиглах хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Хэнтий аймгийн Автотээврийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22,000,000.00 (хорин хоёр сая) төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Дорноговь-А33А” төрийн өмчит хувьцаат компанийд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй

2. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Н.Гүрсөронзон, “Дорноговь-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарын шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

D.Dugan

Д.НАРАНГЭРЭЛ

13201670

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 12
дугаар сарын 28-ны өдрийн 730
дугаар тогтоолын хавсралт

**"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын харьяа Хэнтий аймгийн Автотээврийн
төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг цаашид ашиглах жил үнийг
шинэчлэн тогтоож "Дорноговь-АЗЗА" ТӨХК-д балансаас балансад
шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Балансын, хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ	Цаашид ашиглах хугацаа
1	Тоёото маркийн, 00- 10 ХЭҮ улсын дугаартай, суудлын автомашин, хөдөлгүүрийн дугаар- HDJ810051532	1995/2010	22,000,000.00	2,200,000.00	1 жил
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		22,000,000.00 (хорин хоёр сая)	2,200,000.00 (хоёр сая хоёр зуун мянга)	